



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 119

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын харьяа Авто баазын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 83,300,000.00 (наян гурван сая гурван зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 18,511,111.04 (арван найман сая таван зуун арван нэгэн мянга нэг зуун арван нэгэн төгрөг дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг Шадар сайдын Ажлын алба (Улсын онцгой комиссын шуурхай штаб)-нд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Ц.Уртнасан, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, Цагдаагийн ерөнхий газрын харьяа Авто баазын дарга, хурандаа Ц.Ариунболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



133001397



Төрийн эмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 04 дүгээр сарын 04 ний өдрийн  
дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА АВТО БААЗЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
ШАДАР САЙДЫН АЖЛЫН АЛБА (УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ ШТАБ)-НД  
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Д/д	Автомашинь нэр, улсын бүртгэл, арлын, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Хьюндай соната-DN8, 09-42 УНУ (арал-КМНН.3413ВЛА039741)	2019	37298	83,300,000.00	18,511,111.04	64,788,888.96
	Нийт дүн			83,300,000.00	18,511,111.04	64,788,888.96